



Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын  
11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан  
“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

## “УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: “Увс Хүнс” Хувьцаат компани УБГД: 1510001008, РД: 2001969 Үнэт цаасны код: HUN Хаяг: Увс аймаг, Улаангом сум, 5-р баг Утас: +976-7555-8686 Имэйл: <a href="mailto:info@uvskhuns.mn">info@uvskhuns.mn</a> Вэб хаяг: <a href="http://www.uvskhuns.mn">www.uvskhuns.mn</a>
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хүнсний үйлдвэрлэл, газар тариалан
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	112,716
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Жилийн тайлан бэлтгэсэн: Захиргаа, хүний нөөцийн албаны дарга О.Оюунхүү  Хянасан: Гүйцэтгэх захирал Л.Нямгэрэл



1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт Хөрөнгө Эргэлтийн хөрөнгө Эргэлтийн бус хөрөнгө Нийт хөрөнгө Өр төлбөр ба эздийн өмч Богино хугацаат өр төлбөр Урт хугацаат өр төлбөр Эздийн өмч Нийт өр төлбөр ба эздийн өмч	2024.01.01  2,720,833.7 2,021,951.9 4,742,785.6  316,387.3 900,498.9 3,525,899.4 4,742,785.6	мян.төг 2024.12.31  3,044,502.2 1,880,635.2 4,925,137.4  456,101.4 0 4,469,036.0 4,925,137.4
Орлогын тайлан	Үзүүлэлт Борлуулалтын орлого Борлуулсан бүтээгдэхүүний өртөг Нийт ашиг Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал Орлогын албан татварын зардал Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	2024.01.01  4,839,198.2 2,878,379.3 1,960,818.9  580,574.3 58,083.3 522,490.9	мян.төг 2024.12.31  5,592,134.4 3,206,908.7 2,385,225.7  1,050,306.9 107,170.4 943,136.5
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт Энгийн хувьцаа Нэмж төлөгдсөн капитал Дахин үнэлгээний нэмэгдэл Хуримтлагдсан ашиг Нийт эздийн өмчийн дүн	2024.01.01  11,271.6 3,465.1 847,420.5 2,484,562.6 3,525,899.5	мян.төг 2024.12.31  11,271.6 3,465.1 847,420.5 3,427,699.1 4,469,036.0



		мян.төг	
Мөнгөн гүйлгээний тайлан	Үзүүлэлт	2024.01.01	2024.12.31
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	363,916.5	969,437.6
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(215,805.5)	(51,227.6)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(453,222.2)	(783,025.8)
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(304,909.9)	136,177.3
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	334,303.9	29,394.0
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29,394.0	165,571.3
2.	Жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		
	ГУЗ-ийн дэргэдэх аудитын хороо компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргадаг. Хагас жилийн тайланг Гүйцэтгэх захирлаар батлуулан МХБ-ийн сайтад нийтэлсэн.		
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан дүгнэлт		
3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь	40.5% 42.6%
		Үйл ажиллагааны ашгийн хувь	12.0% 18.8%
		Цэвэр ашгийн хувь	10.8% 16.8%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	14.8% 21.1%
3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа	8.6 6.7
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	2.98 2.35
		Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	0.25 0.1
		Бараа материалын эргэц	1.6 1.71



3.3

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүний үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөнд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл

Монгол улс, Европын Холбоотой дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг энэ онд тэмдэглэн өнгөрүүлсэн. Ойн хүрээнд “Европын холбооны худалдааны өдрүүд” цуврал үйл ажиллагаа болон ЕХ-ны санхүүжилттай“ Монгол улсад гадаад худалдааг хөгжүүлэх “ITDM” төслийн нээлтүүд 05 сарын 11 болон 05 сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Монгол улсаас ЕХ-д Газарзүйн заалтаар бүртгэгдсэн анхны оюуны өмч болох “Увсын Чацаргана”-аар хийгдсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн, амталгааг манай компаниас төлөөлөн хамтран зохион байгуулж оролцсон.





Сүхбаатарын талбайд 2024 оны 05 сарын 11-нд зохион байгуулагдсан Европын холбооны өдөрлөг жил бүр УБ хотод зохион байгуулагддаг “EU day” арга хэмжээнд Монголын “Чацарганы кластер”-ийг төлөөлөн оролцсон.



<p>3.4 Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</p>	<p>Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.</p>
<p>4. Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	
	<p>Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.</p>
<p>5. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэлурамшууллын мэдээлэл</p>	
	<p>Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.</p>



**6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл**

Хувьцаа эзэмшигчдийн хурал

“Увс Хүнс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Увс аймаг Улаангом сум 5-р баг компанийн байр хурлын өрөөнд хуралдан дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэн батлав.
2. 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлав.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг улируулан сонгов. “УВС ХҮНС” Хувцаат Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүд:
  - Л.Мөнхнаран
  - Т.Лхагвасүрэн
  - Л.Нямгэрэл
  - Л.Мөнхтуяа
  - Л.Энхтуяа
  - Л.Батмөнх

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүд:

- А.Чимэд-Очир
- Ж.Бааст
- Н.Оюун

**7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл**

Тайлант хугацаанд Компанийн засаглалын кодексийн шинэчилсэн тайланг 2025 оны 01-р сарын 20-ны өдөр гарган СЗХ-д цахимаар илгээж байна.

Компанийн засаглалын кодексийн хүрээнд:

1. Эрсдэлийн удирдлагын хороо байгуулсан
2. Комплайнсын нэгж, ажилтан томилсон.

Компанийн засаглалын хүрээнд дараах бодлого, хөтөлбөр, журмууд шинээр батлан мөрдөн ажиллаж байна. Үүнд:

1. Залгамж холбооны бодлого
2. Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр
3. Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам
4. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
5. Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам
6. Аудитын хорооны журам



**8. Үйл ажиллагаатай холбоотой нэмэлт мэдээлэл**

**Хүний нөөц**

2024 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 88 ажилтан ажилласан бөгөөд 27 эрэгтэй, 61 эмэгтэй ажилтан ажиллаж байна. Дундаж наслалт 35

23 удаагийн 35 цагийн сургалт хийсэн. Хагас жилд 7 ажилтан шинээр ажилд орсноос 5 ажилтан ажлын байран дээрээ дадлагажиж жинхэлсэн, 3 оюутан үйлдвэрлэлийн дадлага хийсэн. Ажиллагсдын амралтын өрөөний тохижилт хийгдсэн.

**Бизнес ба хүний эрх төсөл**

Япон улсын Засгийн газрын дэмжлэгтэй НҮБХХ-өөс хэрэгжүүлсэн “Бизнес ба хүний эрх” төслийн хүрээнд зөвлөн чиглүүлэх үйлчилгээг 2024 оны 01 сарын 23-03.18-ны өдрийг хооронд авч 5 удаагийн уулзалт хэлэлцүүлэг, 2 удаагийн сургалт зохион байгуулагдаж Сертификат гардан авсан.





2024 оны 01 сарын 20-21-ний хооронд Ховд аймгийн Хар ус нууранд болсон "Мөнгөлөг шагшуурга-2024" баруун бүсийн мөсний баярын үзэсгэлэн худалдаанд зорин очиж оролцсон. МҮХАҮТ-аас баруун таван аймгийн бизнес эрхлэгчдийг нэгдсэн зохион байгуулалтаар ханган баярт дэмжин оролцсон.

✓ Мөсний үзэсгэлэн худалдаанд Увс, Завхан, Говь-Алтай, Ховд гэсэн баруун бүсийн таван аймгийн 70 орчим бизнес эрхлэгч, иргэн, аж ахуйн нэгжүүд идэвх, санаачилгатай оролцсон бөгөөд жимс жимсгэнэ, сүү цагаан идээ, сур суран эдлэл гэх мэт 77 нэр төрлийн бүтээгдэхүүнийг борлуулж, 61.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

✓ Увс аймгаас Увс хүнс, Ойрадын хийц, Хатны улаан ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд идэвхитэй оролцож аймгийн брэнд чацаргана жимс, цагаан идээ, мод модон эдлэлээр хийсэн бүтээгдэхүүнээ сурталчлан, худалдан борлуулсан.







2024 оны 01 сарын 26-27-ны өдрүүдэд Увс Улаангомд зохион байгуулагдсан Сар шинийн үзэсгэлэн худалдаанд шинэхэн бяслаг, чипсэн болон хорхой ааруул, чацарганатай бүтээгдэхүүний бэлгийн багцуудаар оролцож “Шилдэгийн шилдэг үйлдвэрлэгч” Гран При шагнал авсан.





2024 оны 03 сарын 26-нд “Хүнсчдийн баяр”-ыг Хүнс Хөдөө аж ахуйн салбарын шилдэг үйлдвэрлэгч шагнал хүртэн, Ерөнхийлөгчийн цомоор шагнагдсан амжилттайгаар тэмдэглэн өнгөрүүлсэн.



Компанидаа олон жил, үр бүтээлтэй, тууштай ажиллаж байгаа ажилтнуудаа шагнан урамшуулж Төрийн шагнал болох Хөдөлмөрийн хүндэт медалиар 8 ажилтан, ХАА-н тэргүүний ажилтан 3, ХААХҮЯ-ны жуух бичиг 5 ажилтан шагнан урамшуулж нийт 5 сая төгрөгийн мөнгөн шагналаар шагнасан.





"Увс Хүнс" ХК, Улаангом Политехник коллеж хамтран оюутнуудын дунд "Мэргэжлийн ур чадвар"-ын уралдаан 2024 оны 04 сарын 17-ны өдөр амжилттай зохион байгуулсан.





Монголын жимс, жимсгэний салбарын 70 жилийн ойн сургалт хэлэлцүүлэг 2024 оны 04 сарын 18-ны зохион байгуулагдаж “Увс Хүнс”ХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Мөнхнаран 100 га элит сортын чацарганы талбайд “Хөдөө аж ахуйн зохистой дадал”-ыг хэрэгжүүлж МУ-д анх удаа олон улсын аудитын байгууллагаар баталгаажуулсан туршлагаас хуваалцсан.





"Бизнесийн сэргэлт Баруун бүсийн форум" 2024.04.26-04.28-ны хооронд Увс аймагт зохион байгуулагдаж "Увс Хүнс" ХК дэмжигч байгууллагаар оролцсон.

☞ Форумд Увс, Баян-Өлгий, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудын 120 орчим бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүд цугласан.

☞ Үйл ажиллагааны хүрээнд баруун бүсийн хөгжил, худалдаа, хөрөнгө оруулалтын боломж, бодлогын хүрээнд хийгдэж буй ажлуудын танилцуулга, хэлэлцүүлгээс гадна бизнесийн боловсрол, бизнес эрхлэхэд чиглүүлэх сургалтууд болон үйлдвэр аж ахуйн нэгжтэй танилцаж туршлага судлах ажлууд зохион байгуулагдсан.





Форумд Компанийн танилцуулга хийсэн.



"Бизнесийн сэргэлт Баруун бүсийн форум"-ын хүрээнд Эмэгтэй удирдлагатай бизнес эрхлэгчид олгодог "Women owned" гэрчлэх тэмдгийг эзэмшихтэй холбоотойгоор аудитад орж тэнцэн 2024-ны 04 сарын 28-ны өдөр тохирлын гэрчилгээ авсан.



Бизнес форумын төлөөлөгчдөд өглөөний цайгаар үйлчлэн дэмжин оролцсон.



"Бизнес сэргэлт Баруун бүсийн форум"-д оролцсон Баруун 5 аймгийн зочид, төлөөлөгчид 2024.04.28-ны өдөр "Увс Хүнс" ХК-ийн үйлдвэртэй танилцсан.





2024 оны 05 сарын 01-ний өдөр GS1 Mongolia-с Гишүүнчлэлийн Сертификатаа гардан авсан.



The Global Language of Business

## GS1 Mongolia Membership Certificate

GS1 Company Prefix: 8656021160


This is to certify that UVS KHUNS JSC

the real member of "GS1 Mongolia" and uses international standard barcodes.

GS1 Mongolia  
9th floor, "Moriton" complex  
3rd khoroo, Khan-Uul dist  
UB-17032, Mongolia

T +976-77 000 865  
E info@gs1mn.org

www.gs1mn.org

  
Sharbandi TSEVELSAIKHAN  
CEO of GS1 Mongolia



The only organization internationally recognized is authorized to administer the GS1 system in Mongolia

The GS1 Company Prefix shown above is licensed for the sole use of the member named on the certificate. Transfer of numbers formed from this prefix to other companies is prohibited, including but not limited to selling, renting, leasing or donating all or a portion of these numbers.


Эдийн засгийн ногоон шилжилт төсөл-Тойрог эдийн засгийн хурдасгуур хөтөлбөр Европын Холбооны “СВИЧ-Эйшиа” хөтөлбөрийн хүрээнд дөрвөн жил хэрэгжих “Эдийн засгийн ногоон шилжилт” төсөл нь газар тариаланд суурилсан хүнс, ундааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1500 бичил, жижиг, дунд үйлдвэрлэгч, бизнесийн 30 холбоод болон 750 жижиглэн худалдаа эрхлэгчдийг зах зээлийн зарчимд суурилсан эко тэмдэг нэвтрүүлэх замаар тойрог эдийн засагт шилжихэд нь дэмжлэг үзүүлэх төсөл хөтөлбөрт 2024 оны 05 сарын 16-д хамрагдсан.







Хариуцлагатай бизнес ба Албадан хөдөлмөр эрхлэлт” сургалт хэлэлцүүлэг  
МАОЭНХ нь АНУ-ын Хөдөлмөрийн департаментын санхүүжилттэй ОУХБ-ын Бриж-II  
төсөлтэй хамтран ажил олгогчдын болон бизнесийн гишүүнчлэлтэй байгууллагууд, хувийн  
хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллийг хамруулсан “Хариуцлагатай бизнес ба  
албадан хөдөлмөр” сэдэвт семинарт 2024 оны 05-р сарын 30-д хамрагдсан.





2024 оны 09-р сарын 20-23-ны өдрүүдэд Киргизийн Бишкек хотноо “Органик ЭКСПО 2024” Төв Азийн бүс нутгийн форум болж өнгөрсөн. Форумд Казахстан, Узбекистан, Туркменистан, Монгол, Орос, Герман болон бусад 10 гаруй орны 200 гаруй мэргэжилтэн, 50 гаруй илтгэгч оролцов. Төв Азид тогтвортой, ногоон эдийн засгийг бий болгох, органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилготой уг үзэсгэлэнд “Увс Хүнс” компани “Увсын Чацаргана” газарзүйн заалттай түүхий эдээр үйлдвэрлэгддэг Чацарганы бүтээгдэхүүнээ танилцуулан оролцсоноос гадна Газарзүйн заалт нь НҮБ-н тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрхэн дэмжиж орон нутгийн хөгжил, эдийн засагт хувь нэмэр оруулах боломжтой талаарх илтгэл тавьсан.





### "НАМРЫН НОГООН ӨДРҮҮД ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ 2024"

ХХААХҮЯ-аас жил бүр зохион байгуулдаг "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдаа 09-р сарын 23-29 өдрүүдэд төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайд зохион байгуулагдаж Чацарганы шүүс, чацарганы чанамал, Үхэр нүд жимсний шүүс, чанамал, Нэрсний шүүс, чанамал болон бусад бүтээгдэхүүнүүдээр оролцсон.





Монгол улсад шинжлэх ухааны үндэслэлтэй жимс жимсгэнийн салбар үүсч хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд “Азийн бүс нутагт чацаргана болон бусад жимс, жимсгэнийн зах зээлийг хөгжүүлэх” нь сэдвийн дор Герман, БНХАУ, ОХУ, Казакстан, Латви, Непал зэрэг 10 гаруй орны 50 орчим эрдэмтэн, судлаач, бизнес эрхлэгчид манай улсад цуглан 10.30-11.01-ний өдрүүдэд эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав. Уг хурлаар жимс, жимсгэнийн салбарын Монгол болон гаднын эрдэмтдийн бүс нутгийн экосистем, эдийн засгийг хөгжүүлэх, салбарын ололт амжилт, туршлага, бэрхшээл, мэдээллийг хуваалцсан 30 гаруй илтгэл хэлэлцсэн. “Увс Хүнс”ХК нь Увсын чацаргана газарзүйн заалтыг Монгол улс болон Европын холбооны улсад бүртгүүлэхэд түүчээлж ажилласны хувьд газарзүйн заалт, түүний тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийн талаарх илтгэл тавьж оролцсон. Мөн Увс Хүнс ХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Мөнхнаран үйлдвэрлэгч, тариаланчдыг төлөөлөн мэндчилгээ дэвшүүлсэн ба мэндчилгээндээ Жимс, жимсгэний салбарын гол төлөөлөл болох чацаргана жимсгэний тариалан үйлдвэрлэлийг хөгжлийн дараагийн шатанд хүргэх, үйлдвэрлэл бүтээгдэхүүний чанарыг сайжруулаад зогсохгүй, хойч үе байгаль орчинд ээлтэй, тогтвортой тариалан эрхлэхийг уриалсан.





Чацарганын тос 2025 онд герман улсад худалдаалагдана. Монгол Чацарганын тосыг Европын Холбооны улсад худалдаалах ажлыг ITDM төслөөс санаачлан эхлүүлсэн. Увсын Чацаргана газарзүйн заалттай түүхий эдээр хийгддэг Увс Хүнс ХК-н чацарганын үрийн болон зөөлөн эдийн тос нь тус улсад худалдаалагдах чанарын шаардлагыг хангасан бөгөөд тэдгээр бүтээгдэхүүнүүдийн шошгийг ЕХ-ны улсын холбогдох хууль журамд нийцүүлэн өөрчлөх талаар ITDM төслийн ахлах эксперт Карл Круг бол төслийн зөвлөх Аксел Вайлинг нар санал солилцов.

Монгол Чацарганы тосонд агуулагдах Витамин К, Е болон Омега 3, 6 тосны хэмжээ өндөр илэрсэн нь ЕХ-ны улсууд ялангуяа Германы зах зээлд үнэ цэнтэй байх тул тэжээллэг үзүүлэлтийн хэсэгт оруулахаар харилцан зөвшөөрөв. Увс Хүнс ХК-н чацарганы үрийн тосны Витамин К хэмжээ 1230мкг/100гр гарсан нь Дэлхийд хамгийн өндөр үзүүлэлт гэдгийг Герман зөвлөх онцгойлон дурдсан.





Увс аймгийн Онцгой байдлын газартай хамтарсан "Тактикийн сургуулилт" 2024.12.13-ны өдөр амжилттай зохион байгуулагдсан.

- Увс аймгийн Онцгой байдлын газар, Улаан загалмайн нийгэмлэг, "Увс Хүнс" ХК хамтран зохион байгуулав.

Тактикийн сургуулилтад дараах агуулгаар сургалт орсон. Үүнд:

- Гал түймэр түүний тухай, урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ

- Галын аюулгүй байдалтай холбоотой холбогдох хууль тогтоомжууд

- Анхны тусламж гэж юу вэ?

- Анхны тусламж хэрхэн үзүүлэх вэ?, бэртэл гэмтэлтэй хүнд үзүүлэх тусламж, боолт сойлт хийх арга

- Сэхээн амилуулах тусламж хэрхэн үзүүлэх.



ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР



УВС ХҮНС  
Эрүүл хүнс аз жаргалын эхэлэлт





"УВС ХҮНС" ХК "Улаангом политехник коллеж"-ийн 2024 оны "Шилдэг түншлэгч" байгууллагаар тодорч 2024.12.31-ний өдөр гардан авлаа.



<p><b>Нэгдсэн удирдлагын тогтолцоо</b></p>	<p>2018 оноос олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 стандарт, хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000:2018 стандартуудыг хэрэгжүүлэн жил бүр дотоод аудитаар хянан ажиллаж байна.</p>
<p><b>Эрсдэл, дотоод аудит</b></p>	<p>Дотоод аудитын хөтөлбөрийн дагуу жилд 2 удаа аудитын төлөвлөгөө боловсруулан үйлдвэрийн нэгж, албадуудад дотоод аудит хийдэг. Эрсдлийн бүртгэл, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн арга хэмжээний хэмжилтийг ханган, удирдлагын дүн шинжилгээний хурлаар чанарын багт хэлэлцүүлэн шийдвэрээ гаргадаг.</p>
<p><b>Нийгмийн хариуцлага</b></p>	<p>Ажиллагсадын гэр бүлд шинээр мэндэлсэн хүүхдэд 300,000 төгрөгийн хадгаламж нээж, 37 хүүхэд хадгаламжтай боллоо. Ажилтнуудаа хурим хийх, шинэ байранд орох болон шинэ гэр барих ар гэрт гачигдал зовлон тохиох, 3-р шатлалын эмнэлэгт эмчлүүлэх зэрэгт тэтгэмж олгон нийгмийн асуудалд нь анхааран ажиллаж байна.</p>



2024 оны 04-р сард хамгийн эхний “Youth Power” байгальд ээлтэй залуусын чуулган Увс аймагт боллоо.

Нийт 2 хоногийн турш 9 сум, 26 сургуулийн, 81 манлайлагч хүүхдүүд 9 дэд сэдвийн хүрээнд чуулсан бөгөөд Увс аймгийн салбар бүрийн шийдвэр гаргагчдыг урьж оролцуулан, чуулганаас гарсан санал санаачилгаа танилцуулж тогтоол бичгээ гардуулсан чуулганд дэмжигч байгууллагаар орролцсон.



Ажилчдынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамтач нийтэч уур амьсгалыг бүрдүүлэхийн тулд уламжлал болгон зохион байгуулагддаг шилжин явах цомын тэмцээн зохион байгууллаа.







Монгол улсын 17 насны улсын аварга шалгаруулах тэмцээн дархан хотод боллоо  
Ивээн тэтгэгчээр ажиллаж биднийг боломж бололцоогоороо дэмжсэн Гантөмөр Цэдэн-Ишийн  
Улаангом Сум, Увс аймгийн Биеийн Тамир, Спортын газар, Sengesambuу Laihan Дэндэв Замба,  
Увс Хүнс ХК/ Uvs Khuns JSC

Та бүхэндээ баярлалаа



Увс аймгийн үйлдвэрлэл үйчилгээ эрхлэгчид тариаланчдын дунд жил болгон уламжлал болгон зохион байгуулагддаг “УВС ТҮНШЛЭЛ МИНИЙ МОНГОЛ-2024” арга хэмжээнд оролцсон.





“Хүүхэд бүрт Хүний эрхийн боловсрол” Карл Попперын мэтгэлцээний улсын аварга шалгаруулах 9-р тэмцээний суралцагчдыг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжин оролцсон. Багийн нэрээ манай компанийн Амта брэндээр нэрлэн оролцож 1-р байр эзэлсэн байна.







### Бүтээгдэхүүн

Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэхээр нийт ТНБЦ-ийн ажилчдын дунд ур чадварын уралдаан зарлаж нийт 13 ажилтан 23 нэр төрлийн бүтээгдэхүүн хийж гүйцэтгэснээс ажилтан Ү.Эрдэнэчимэг 85 оноо авч нэгдүгээр байр эзэлсэн Аарцат бүтээгдэхүүнийг худалдаанд гаргаад байна.

80 оноо авч Ц.Орлом хоёрдугаар байр, 78 оноо авч Ц. Тунгалаг гуравдугаар байр тус тус эзлэн оролцсон.




Нарийн боовны цех нь шинээр 3 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн борлуултад гарган ажиллаж байна .





Сүүний үйлдвэрлэл 6 сард үйл ажиллагаа эхэлсэн.




Сүүн зайрмаг худалдаанд гарлаа.





Сүү, шар сүүгээр зөөлөн чихэр үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр болов.



Жимсний чанамал **Нэрсгэй** төрлөө шинээр нэмж 3 төрлийн жимсний чанамалаа дангаар болон бэлгийн багцаар борлуулалт хийж эхэлсэн.

Аньс, нэрсээр төрлөө нэмж 4 төрлийн шүүсээ дангаар болон бэлгийн багцаар худалдаалж байна.





Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Л.Нямгэрэл

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: О.Оюунхүү

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: